

Түүхийн улсын олимпиадын II давааны багшийн сорил-2024

1. Монголын дээд палеолитын соёлт давхаргат суурин аль вэ? (Зөв хариулт бүр 0.5 оноо, нийт 2 оноо)
  - a. Нарийн гол
  - b. Дөрөлж
  - c. Харганын гол
  - d. Байдрагийн гол
  - e. Олон нуур
  - f. Их Төлбөрийн гол
  - g. Цацын эрэг
  - h. Бодонч гол
2. Н.Н.Диков, Н.Л.Членов нарын буган хөшөөний утга зүйн талаар дэвшүүлсэн санал аль вэ? (1 оноо)
  - a. Хүн дүрсэлсэн чулуун хөшөө
  - b. Дээд, дунд, газар доорх ертөнцийн бэлгэдэл
  - c. Хүний төрөхөөс үхэх хүртэлх амьдралын гурван үе
  - d. Буган өвөг, нар ба онгон шүтээнд зориулагдсан
  - e. Булшинд хүн орлуулж оршуулдаг хөшөө
3. Г.Сүхбаатарын үзсэнээр хятад сурвалжид тэмдэглэсэн “фэньди” аль вэ? (1 оноо)
  - a. Шаньюйн ан авын нутаг
  - b. Хилийн бүс нутаг
  - c. Харь овог аймгийн нутаг
  - d. Хүн нутагладаггүй орхигдсон нутаг
  - e. Түмтийн нутаг
4. Хүннүгийн төр, цэрэг-засаг захиргааны албан тушаал гудохоу-д аль овгоос томилогдож байсан бэ? (1 оноо)
  - a. Сюйляньти / Люаньти
  - b. Хуянь
  - c. Сюйбу
  - d. Лань
  - e. Цюлинь
5. Түрэгийн Ашина-гийн домог, Усуний Куньмо-гийн намтартай 8 зүйлээр тохирч буйг тогтоосон эрдэмтэн аль вэ? (1 оноо)
  - a. Ю.А.Зуев
  - b. С.Г.Кляшторный
  - c. Г.Сүхбаатар
  - d. Л.Н.Гумилев
  - e. Г.Е.Грумм-Гржимайло
6. Уйгурын тотем шүтлэг аль вэ? (1 оноо)
  - a. Чоно
  - b. Шонхор
  - c. Бух
  - d. Буга
  - e. Хус хуш
7. Монгол улсын нутгаас илэрч олдсон согд бичгийн хоёр дурсгал аль вэ? (Зөв хариулт бүр 1 оноо, нийт 2 оноо)
  - a. Их Хөшөөтийн хөшөө
  - b. Рашаан хадны бичээс
  - c. Бугатын бичээс
  - d. Хар балгасын бичээс
8. Хятан улс Хятадын түүхийн аль үетэй таарах вэ? (Зөв хариулт бүр 1 оноо, нийт 2 оноо)
  - a. Сүй улс
  - b. Таван үе, арван улсын үе
  - c. Тан улс
  - d. Сүн улс
  - e. Умардын таван ху-гийн 16 улс
9. Хэрэйд улсын хангуудыг зөв дараалуулсан нь аль вэ? (1 оноо)
  - a. Сарык, Маркус, Куржакуз, Тоорил
  - b. Маркус, Сарык, Куржакуз, Тоорил
  - c. Маркус, Куржакуз, Сарык, Тоорил
  - d. Сарык, Куржакуз, Маркус, Тоорил

10. “Энэ эеэ бүү эвдэгтүн, эв зангиан бүү тайлагтун...” хэмээн хэн хэлсэн бэ? (1 оноо)
- a. Чингис хаан      b. Тоорил хан      c. Өүлэн үжин      d. Жамуха
11. Сурвалжийн мэдээгээр Хорезмын султан жилд 1500 динар татварлан авдаг байсан хот аль вэ? (1 оноо)
- a. Бухар      b. Самарканд      c. Нур      d. Ургенч
12. Гүюг хааны үед дараах газар нутгийг хэн, хэн захирч байсныг нөхөж бичнэ үү. (Зөв хариулт бүр 1 оноо, нийт 3 оноо)
1. Баруун Ази      2. Умард Хятад      3. Төв болон Дундад Ази
- a. ....      b. ....      c. ....
13. Батмөнх Даян хааны эсрэг бослого гаргасан хоёр аймаг аль вэ? (Зөв хариулт бүр 1 оноо, нийт 2 оноо)
- a. Горлос      b. Юншээбүү      c. Хорчин      d. Ордос
14. Дараах өгүүлбэрээс зөв 2 өгүүлбэрийг дугуйлна уу. (Зөв хариулт бүр 1 оноо, нийт 2 оноо)
- a. Мин улс Нагачу жанжны цэргийг Чанчунь хотын ойролцоо дайлав.  
b. 1440 онд Эсэн тайш Мин улсын Ин зун хааныг довтлон ялжээ.  
c. Алтан хан 1552 онд Хөх нуурыг, 1557 онд Ойрадыг довтлов.  
d. Орос улс эзэлсэн газар нутагтаа шивээ бэхлэлт барьж бэхжиж байв.
15. Амарсанааг хэзээ, хаана Зүүнгарын хаанаар өргөмжилсөн бэ? (1 оноо)
- a. 1755, Эрээн хавирга      b. 1756, Бор тал  
c. 1756, Ховогсайр      d. 1757, Или
16. Манжийн төр Хөх нуурын монголчуудыг хэдэн хошуунд хуваасан бэ? (1 оноо)
- a. 49      b. 86      c. 29      d. 32
17. Академич Б.Ширэндэвийн бүтээл аль вэ? (Зөв хариулт бүр 1 оноо, нийт 2 оноо)
- a. Монгол ардын хувьсгалын түүх  
b. Ардын Хатанбаатар Магсаржавын намтар  
c. Ардын хувьсгалын манлай хүчин  
d. Ардын төрийн түүх  
e. Монгол оронд ард ангийн хувьсгалт нам үүсэн байгуулагдсан асуудал
18. Дараах бичвэрийг уншаад асуултад хариулж бичнэ үү.  
“Дундад улс Гадаад Монголын өөртөө эзэрхэхийг хүлээн зөвшөөрөв” (Зөв хариулт бүр 1 оноо, нийт 3 оноо)
- a. Энэ ямар баримт бичгийн заалт вэ? .....  
b. Энэ баримт бичигт ямар улс гарын үсэг зурсан бэ? .....  
c. Энэ баримт бичгийг хэдэн онд байгуулсан бэ?.....
19. 1924 оны Үндсэн хуулийн бүлгийг буруу бичсэн нь аль вэ? (Зөв хариулт бүр 1 оноо, нийт 2 оноо)
- a. Монголын жинхэнэ ардын эрх чөлөөг илтгэн тунхаглах нь  
b. Улсын дээд эрхийг барих газрын тухай  
c. Нутгийн засаг захиргааны байгуулалт, удирдлагын тухай  
d. Сонгох, сонгогдох эрхийн тухай  
e. Улсын орлого зарлагын эрхийн тухай

f. Улсын сүлд тэмдэг ба далбааны тухай

20. 1924 оны 10 сарын 24-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаас байгуулсан Үндсэн хууль боловсруулах комиссын бүрэлдэхүүнд хэн багтаагүй вэ? (Зөв хариулт бүр 1 оноо, нийт 2 оноо)

- a. Б.Цэрэндорж                      b. Ж.Цэвээн                      c. Э. Ринчино  
d. Гомбобадамжав                      e. Бат-Очир                      f. Н.Магсаржав

21. Анхдугаар Үндсэн хуулиар УИХ-ын төлөөлөгчдийн бүрэн эрхийн хугацааг хэдэн жилээр тогтоосон бэ? (1 оноо)

- a. 1 жил                      b. 2 жил                      c. 3 жил                      d. 4 жил                      e. 5 жил

22. БНМАУ-ын анхдугаар Үндсэн хуулийн заалтыг гүйцээж бичнэ үү.

“Тус улсын харьяат ард түмэнд угсаа, ....., эрэгтэй, эмэгтэй гэдэг ялгаваргүй нэгэн адил эрхийг эдлүүлбэл зохино”. (1 оноо)


23. 1924 оны Үндсэн хуулинд БНМАУ-ын гадаад бодлогыг хэрхэн тодорхойлсон бэ? (1 оноо)

- a. Улс төр, нийгмийн байгуулал харгалзахгүй тэгш харилцаа тогтоох  
b. Тус улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд онц тустайг тэргүүнд тавьж харилцах  
c. Засгийн эрх нь ард түмэнд шилжсэн улсуудтай харилцах  
d. Цэргийн түрэмгий бодлогогүй, энх тайванч улсуудтай харилцаа тогтоох  
e. Бага буурай ба хувьсгалт ард түмний үндсэн зорилготой нийлүүлэн явуулах

24. Мэдээллийг уншиж, цэгийн оронд тохирох үгийг бичнэ үү (Зөв хариулт бүр 0,5 оноо, нийт 3 оноо)

Кирийн цилиндрийг .....(a. он) персүүд Вавилон хотыг эзлэн авсны дараа Кир хааны зарлигаар шавар бортого дээр үйлджээ. Уг бичээсийг .....(b. хэл) хэлээр, .....(c. бичиг) бичгээр үйлдсэн байдаг. Уг олдворыг .....онд (d. он) Вавилоны малтлагын үеэр олж, ..... музейд (e. музейн нэр) хадгалжээ. 1960-аад онд ..... (f. албан тушаалтан) уг олдворыг “хүний эрхийн анхны тунхаглал” хэмээн зарлажээ.

25. Газар зүйн зургийг ажиглаж, зөв өгүүлбэрийг дугуйлна уу (Зөв хариулт бүр 0,5 оноо, нийт 2 оноо)



- a. Газар зүйн зурагт Арабын эзэнт улсыг дүрсэлсэн  
b. 1-ийн тоогоор тэмдэглэсэн газрыг 756 онд франкууд эзлэн авсан

- c. 2 -ын тоогоор Персийн буланг тэмдэглэсэн
- d. 3 -ын тоогоор тэмдэглэсэн хотыг 1258 онд монголчууд эзлэн авсан
- e. 3-ын тоогоор тэмдэглэсэн хот одоогийн Иран улсын нийслэл юм
- f. 4 -ийн тоогоор одоогийн Истанбул хотыг тэмдэглэсэн
- g. 5 -ын тоогоор ислам шашин үүссэн газрыг тэмдэглэсэн
- h. 6 -ын тоогоор тэмдэглэсэн нутгийг Машрик гэдэг байв.

26.Европын 3 орны түүхэнд холбогдох үйл явдлыг жагсаав. Хүснэгтэд улсын нэр, холбогдох үйл явдлыг ялгаж бичнэ үү. (Зөв хариулт бүр 0,5 оноо, нийт 6 оноо)

- a. I эзэнт улсыг үндэслэв
- b. Чартист хөдөлгөөний үр дүнд үйлдвэрчний эвлэлийн байр суурь бэхжив
- c. “Соёлын төлөө тэмцэл”-ийг эхлүүлэв
- d. 1871 онд Эльзас, Лотаринг мужийг булаан авав
- e. Бурын хоёр БНУ-ын эсрэг дайн дэгдэв
- f. 1896 онд “дэлхийн бодлого” гэгчийг тунхаглав
- g. Луизианаг АНУ-д худалдав
- h. Исмаил пашаас Суэцийн сувгийн хувьцааг худалдан авав
- i. Луи Орлеон засгийн эрхэнд гарав

Улсын нэр	1. ....	2. ....	3. ....
Холбогдох түүхэн үйл явдал	1..... 2..... 3.....	1..... 2..... 3.....	1..... 2..... 3..... ..

27.Хүснэгтэд орхигдуулсан он цаг, үйл явдал, уг үйл явдал болсон улсыг нөхөж бичнэ үү. (Зөв хариулт бүр 0,5 оноо, нийт 4 оноо)

№	Он цаг	Үйл явдал	Улс
1	1840-1842	.....	Манж Чин улс
2	.....	Мэйжийн хувьсгал	Япон
3	1857-1858	Сипайн бослого	.....
4	1839	.....	Османы ЭУ
5	1869	Суэцийн сувгийг нээв	.....
6	.....	Үндэсний Конгресс нам байгуулагдав	Энэтхэг
7	1848-1852	Бабидын бослого	.....
8	.....	Симоносекийн гэрээ	Манж Чин улс-Япон